

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	2
1.1 Төслийн нэр .....	2
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл .....	2
1.3 Төслийн хүчин чадал .....	3
1.4 Төслийн дэд бүтэц .....	5
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	7
2.1 Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл .....	7
2.2 Хөрс, хөрсөн бүрхэвч .....	7
2.4 Ургамлан нөмрөгийн төлөв байдал .....	7
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ .....	10
2.4 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл .....	11
БҮЛЭГ 4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	13
4.1 МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	13
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	20
БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	21
БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	22
БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	22
БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	22
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	24
БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	26
БҮЛЭГ 13. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ .....	28
БҮЛЭГ 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ .....	30

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг №. 1 Төсөл хэрэгжих талбайн байршил .....	3
Зураг №. 2 Ордын баяжуулах технологи .....	4
Зураг №. 3 Уурхайн техникийн технологийн холболт .....	4
Зураг №. 4 Уурхайн дотоод тээвэрлэлтийн зам .....	6
Зураг №. 5 Төсөл хэрэгжих талбайн хөрсний тархалт .....	7
Зураг №. 6 Төсөл хэрэгжих талбайн ургамлын тархалт .....	8
Зураг №. 7 Төслөөс үзүүлэх нөлөөллийн үнэлгээ .....	11

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл .....	2
Хүснэгт №. 2 Талбайн солбилцол .....	2
Хүснэгт №. 3 Уурхайн ажиллах горим .....	3
Хүснэгт №. 4 Уурхайн ашиглалтын технологи .....	3
Хүснэгт №. 5 Уурхайн дэд бүтэц, талбай .....	5
Хүснэгт №. 6 Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөлөх байдлын үнэлгээний нэгдсэн дүгнэлт ..	11
Хүснэгт №. 7 БОМТ-ний зардалын задаргаа .....	14
Хүснэгт №. 8 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	15
Хүснэгт №. 9 Техникийн нөхөн сэргээлт .....	20
Хүснэгт №. 10 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ .....	21
Хүснэгт №. 11 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө .....	22
Хүснэгт №. 12 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	24
Хүснэгт №. 13 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	26
Хүснэгт №. 14 БОМТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга .....	28
Хүснэгт №. 15 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь .....	30

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн нэр

“Илжигтэйн доод хэсэг”-ийн алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

**Төслийн зорилго:** Төсөл хэрэгжүүлэгч “Монголламбер” ХХК нь Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Жаргалтхаан сумдын нутагт орших “Илжигтэйн доод хэсэг”-ийн алтны шороон ордод 2021 оноос олборлолтын үйл ажиллагаа явуулах гэж байгаа бөгөөд Монгол Улсын хууль, холбогдох дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайн ашиглалтыг явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

### 1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

“Монголламбер” ХХК нь Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Жаргалтхаан сумдын нутагт орших “Илжигтэйн доод хэсэг”-ийн алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн ТЭЗҮ-г 2020 онд батлуулсан өгөөд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг мөн 2020 онд батлуулж 2021 оноос эхлэн үйл ажиллагаагаа эхлүүлэх гэж байна.

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

<b>Төсөл хэрэгжүүлэгч</b>	<b>“Монголламбер” ХХК</b>
Улсын бүртгэлийн дугаар	9011419139
Регистрийн дугаар	5747392
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-021583
Хаяг	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо, 1-р хороолол 15-03 тоот
Утас	96666599


**Төслийн байршил:** “Монголламбер” ХХК нь Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Жаргалтхаан сумдын нутаг дэвсгэрт байрлах MV-021583 тоот лицензийн дугаартай 879.52 га газарт ашигт малтмал ашиглахыг зөвшөөрсөн тусгай зөвшөөрлийг авсан байна.

“Илжигтэйн доод хэсэг”-ийн алтны шороон орд MV-021583 дугаартай тусгай зөвшөөрлийн 879.52 га талбай нь Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Жаргалтхаан сумдын нутагт, Улаанбаатар хотоос зүүн урагш 180 км, Хэнтий аймгийн төв Өндөрхаанаас 125 км, Жаргалтхаан сумын төвөөс 35 км зайтай оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлөөр эзэмшиж буй талбайн захын цэгүүдийн солбицолыг хүснэгтэд харуулав.

Хүснэгт №. 2 Талбайн солбилцол

№	Уртраг	Өргөрөг
1	109° 12' 01.64"	47° 35' 31.77"
2	109° 12' 01.64"	47° 35' 30.57"
3	109° 10' 28.64"	47° 36' 38.43"
4	109° 09' 56.28"	47° 36' 49.23"
5	109° 09' 56.28"	47° 37' 31.76"
6	109° 12' 36.64"	47° 37' 31.76"
7	109° 12' 36.64"	47° 35' 46.76"
8	109° 12' 21.64"	47° 35' 46.76"
9	109° 12' 21.64"	47° 35' 31.77"

**“ИЛЖИГТЭЙН ДООД ХЭСЭГ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАН,  
БАЯЖУУЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



**Зураг №. 1 Төсөл хэрэгжих талбайн байршил**

**1.3 Төслийн хүчин чадал**

“Илжигтэйн доод хэсэг”-ийн ын алтны шороон ордыг ашиглах ил уурхайн хүчин чадлыг захиалагч байгууллагын саналыг үндэслэн жилд 113.7 мян.м3 элс олборлохоор ТЭЗҮ-д тусгасан байна. Уурхайг 2 жилийн хугацаанд ашиглана.

**Уурхайн ажиллах горим**

“Илжигтэйн доод хэсэг”-ийн алтны шороон ил уурхайд нийт 48 хүн ажиллах ба ил уурхайн хэсэгт хоногт 2 ээлжээр, ээлжинд 12 цагаар ажиллах бөгөөд цайны цаг, ээлж хүлээлцэх ээлжийн бэлтгэл төгсгөл цаг зэргийг хасч тооцсоноор хоногт 20 цаг ажиллахаар тооцлоо. Уурхайн цаг ашиглалтын коэффициент 0.83, жилд 2180 мот.цаг ажиллах хязгаартай байна

Хүснэгт №. 3 Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
2	Хоног дахь ээлжийн тоо	ээлж/хон	2
3	Жилд ажиллах хоногийн тоо	хоног/жил	116
4	Жилд ажиллах ээлжийн тоо	ээлж/жил	232
5	Жилийн ажлын цагийн хэмжээ	цаг/жил	2,784


**Уурхайн ашиглалтын систем**

“Монголламбер” ХХК-ны уг ордыг ил аргаар тээвэртэй ашиглалтын системээр ашиглана. Уурхайн технологи агуулгын хувьд бульдозероор хөрсийг түрж овоолох, экскаватороор элсийг ухаж автосамосвалд ачин тээвэрлэн угаах хэсгийн эслний овоолгод хураана.

Хүснэгт №. 4 Уурхайн ашиглалтын технологи

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Тээвэртэй, гадаад, дотоод овоолготой ашиглалтын технологи	1. Хөрс хуулалт	1.1. Шимт хөрс түрж хуулах, овоолох 1.2. Хөрс түрж хуулах, овоолох
	2. Олборлолт	2.1. Ухаж ачих 2.2. Тээвэрлэх 2.3. Овоолох (агуулахад хураах)

Ил уурхайн ашиглалтын технологийн процессууд




“Илжигтэйн доод хэсэг”-ийн алтны шороон ордод ил уурхай байгуулан олборлолт явуулах, олборлосон хүдрийг бутлаж, нунтаглан баяжуулж, алтыг борлуулах үйл ажиллагаа төслийн цар хүрээг хамарна.

Элс баяжуулах технологи

Ил уурхайн олборлолтын төлөвлөгөө, технологийн туршилтын үр дүн, алтны шороон ордын үйлдвэрийн практикт үндэслэн баяжуулах хэсгийн төлөвлөлт, технологийн горим болон бүтээгдэхүүн гаргалт, зарцуулагдах усны хэмжээ, тоног төхөөрөмжийн хүчин чадал болон сонголтыг тооцоог хийж гүйцэтгэлээ. Ордын элс баяжуулах хэсэг нь хамгийн ихдээ сард 37.97 мян.м3 элс баяжуулна.

Элс баяжуулах хэсэг нь өдөрт 2 ээлжээр, нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна. 7-р сараас эхлэн уурхайн бэлтгэл ажлыг хийж, ил уурхайгаас олборлосон элсийг нөөцлөн 8-р сараас эхлэн баяжуулах хэсэг элсийг угаан, бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэнэ.



Зураг №. 2 Ордын баяжуулах технологи

#### 1.4 Төслийн дэд бүтэц

**Уурхайн хотхон:** Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Жаргалтхаан сумдын өнөөгийн дэд бүтцийн товч судалгаа, Илжигтэйн ордыг ашиглахад шаардлагатай дэд бүтэц болох уурхайн цахилгаан хангамж, ус хангамж, дулаан хангамж, хотхоны барилга болон зам, харилцаа холбоог тусгаж өгөв.

Уурхайн захиргаа, уурхайн кемьп 0.9 км, засвар үйлчилгээний төв, шатахуун агуулах зэрэг барилга байгууламжууд уурхайгаас 0.55 км зайд тус тус байрлах бөгөөд нийт 0.2 га талбайг эзлэн байрлана. “Монгол Ламбер” ХХК-ийн Илжигтэйн уурхайд барих барилга байгууламжууд, бүтээц эдлэл, хэмжээг доорх хүснэгтэнд тусгалаа.

Хүснэгт №. 5 УУРХАЙН ДЭД БҮТЭЦ, ТАЛБАЙ

№	Барилгын нэр	Х.нэгж	Хэмжээ	Тайлбар
<b>Хотхон</b>				
1	Уурхайн удирдлагын байр	м <sup>2</sup>	28.4	Засч тохижуулсан 40 тн контейнер хаус
2	Ажилчдын сууц	м <sup>2</sup>	112.0	Засч тохижуулсан 40 тн контейнер хаус
3	Цайны газар	м <sup>2</sup>	28.4	Засч тохижуулсан 40 тн контейнер хаус
4	Халуун ус болон угаалга	м <sup>2</sup>	28.4	Засч тохижуулсан 40 тн контейнер хаус
<b>Ил уурхай</b>				
5	Сэлбэгийн агуулах	м <sup>2</sup>	28.4	40 тн контейнер 1 ш
6	Түлшний ёмкост	тн	20.0	Уурхайн 4 хоногийн хэрэглээ
7	Харуулын байр	м <sup>2</sup>	4x3	12 м2 талбайтай 3 ш сэндвичин байр

**Уурхайн тосгон:** Уурхайн ажилчдыг байрлуулах тосгон ил уурхайгаас 0.9 км зайд, тусгай зөвшөөрлийн талбай дотор байрлана. Ажилчдын хотхоныг нийт 50-60 хүн зэрэг байрлах хүчин чадалтайгаар төлөвлөж шаардлагатай барилга байгууламж, тавилга, эд хогшлыг тооцсон.

**Холбооны байгууламж:** Уурхайн тосгонд үүрэн холбооны Юнитель ХХК-ийн сүлжээ бүрэн барьдаг. Уурхайд экскаватор, дугуйт ачигч, автосамосвал зэрэг үндсэн тоног төхөөрөмжийн операторууд, ээлжийн дарга нар богино долгионы радио холбоогоор хангагдана. Уурхайн тосгонд сансрын антенн суурилуулж телевизийн сувгууд хүлээн авна.

**Түлшний агуулах:** Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангана. Түлшний агуулах нь 4 хоногийн нөөц буюу 20 тн түлш хадгалах багтаамжтай байна. Эдгээр нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй байна. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах, аянга зайлуулагч хэрэгслүүд байрлана. Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийж өгнө.

**Засвар механикийн барилга байгууламж:** Уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг үйлдвэрийн талбайд байрлах засварын хэсэгт хийж гүйцэтгэнэ. Засварын хэсэгт дугуйт засвар, гагнуур, кран, компрессорын станц зэргийг байгуулна.


**Цахилгаан, дулаан хангамж:** Цэнхэрмандал, Жаргалтхаан сумд нь 1994 онд төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон байдаг байна. Энэ цагаас үеэс хойш өргөтгөл, сайжруулалтын ажил огт хийгдээгүй байсан бөгөөд 2019 оны 8-р сараар 2020 оны 1-р сарын хооронд “Цэнхэрмандал” дэд станцыг өргөтгөх ажил хийгдэж дуусан байна. Ингэснээр Жаргалтхаан сумын цахилгаан эрчим хүчний чадлыг сайжирсан ба тус станцын хүчин чадал 35/6 квт-аар нэмэгдсэн байна. Шинээр татсан агаарын шугам 44.5 км урт, 35 киловаттын хүчин чадалтай аж. Эрчим хүчний бүтээн байгуулалтын хүрээнд Жаргалтхаан дэд станцын барилгын ажлыг мөн гүйцэтгэсэн байна.

Цэнхэрмандал, Жаргалтхаан сумдын төвийн төсвийн байгууллагууд, бусад барилга байгууламжуудыг бага оврын уурын зуухаар халаадаг байна.

**Усан хангамж:** Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын газарт байрлах “Илжигтэйн доод хэсэг”-ийн ордын технологи, ажилчдын унд ахуйн ус болон тоосжилт дарах ажлын хэрэглээнд зориулан 2016 оны 06-р сарын 22-нд 1 ширхэг худгийг гаргасан байна. Худгийн байршил (109° 11' 0.84", 47° 37' 35.66"), болон амсрын өндөржилт 47 метрийн түвшинээс 56 м гүнд өрөмдлөг явуулж гүний худаг гаргасан байна. Дээрх худгийн ундрага нь 8 л/сек байна.



**Уурхайн зам:** Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум нь зүүн хойд талаараа Өмнөдэлгэр сум, зүүн урд талаараа Жаргалтхаан сум, өмнөд талаараа Дэлгэрхаан сум, баруун хойд талаараа Төв аймгийн Мөнгөнморьт сум, баруун талаараа Багануур дүүрэг Хэрлэн голоор хиллэж оршдог. Тус сумын төв буюу Баянмод баг нь зүүн чиглэлийн мянганы зам дагуу Улаанбаатар хотоос 200 км, Чингис хотоос 150 км-т оршдог.



Зураг №. 4 Уурхайн дотоод тээвэрлэлтийн зам

### Хог хаягдлын менежмент

“Монголламбер” ХХК нь Хог хаягдлын цэгийг байгуулахдаа салхины зонхилох чиглэлийн доор орон нутгийн БО-ны байцаагчийн тогтоосон цэгт байгуулж, уурхайн үйл ажиллагаанаас гарах нийт хатуу хог хаягдлын дахин ашиглагдах хаягдлуудыг ангилан ялгах, овор хэмжээг нь багасгах зэргээр байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг бага байлгах шаардлагыг биелүүлэн ажиллана. Мөн ахуйн гаралтай бусад хог хаягдлыг зайлуулах гэрээг сум, орон нутгийн удирдлагатай хийж, гэрээний дагуу тогтмол хугацаанд тээвэрлүүлнэ. Шингэн хог хаягдлыг цэвэрлэх байгууламж байгуулан байгаль орчинд халгүй арга хэлбэрээр зайлуулах, дахин ашиглах арга хэмжээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн 2019 оны 05 сарын 02нд батлагдсан нэмэлт өөрчлөлтийг, Усны тухай хуулийн 3.1.32, 3.1.33, 25, MNS 4943:2015 стандарт, 2.2-2.4, 25 дугаар зүйлийн 25.1, 8 дугаар зүйл, зэргийг дагаж мөрдөнө ажиллана.


## БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1 Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл

Төслийн талбай нь Хэнтийн нурууны салбар уулсын баруун өмнөд хэсэгт байрладаг бөгөөд уулс нь мөлгөр бүнхэр оройтой, налуу хааяа эгц хажуутай, далайн түвшинээс дээш 1550-1583 м дундаж өндөртэй. Цэнхэрмандал сумын нутаг дэвсгэрт Цэнхэрмандал, Мааньт, Өндөр Хутаг, Жаргалант, Ерөөлтийн хангай, Хөх шувуут зэрэг өндөр уулс бий. Бүс нутаг нь хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд намхавтар уулс хооронд томоохон уужим хөндий тал үргэлжлэх ба энэ нь улмаар өмнө зүгт тал хээрийн бүсэд шилжинэ. Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь газрын гадаргын хувьд баруун талаараа хадан гарштай мөлгөр орой бүхий хэрчигдэл багатай, төв болон зүүн хойд хэсэгт харьцангуй хэрчигдэл ихтэй, уулын ар тал нь эгц налуу гадаргатай.

### 2.2 Хөрс, хөрсөн бүрхэвч

Цэнхэрмандал, Жаргалтхаан сумдын хувьд нутгийн ихэнхи хэсгээр унтаг карбонатлаг хар хүрэн хөрс тархсан. Уг хөрс нь уулын хээрийн хөрсний хэв шинжийн хөрс бөгөөд ялзмагт үеийн доороос эхлэн нунтаг карбонатын нэвчмэл цайвар өнгөр толботой, ихэнхдээ А-АВ-Вса-ВСа-Сса гэсэн үе давхаргуудтай, давсны хүчилд 30-50 см гүнд, хааяа 15- 20 см-ийн гүнээс бургиж карбонатын давсны хуримтлалтай байна.



ЗУРАГ №. 5 ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН ХӨРСНИЙ ТАРХАЛТ


### 2.4 Ургамлан нөмрөгийн төлөв байдал

Ургамлын бүлгэмдэл, тэдгээрийн бүрэлдэхүүний газарзүйн тархалтын зүй тогтол нь уулархаг нутаг оронд босоо бүслүүрээр тод илэрч, харин тал нутагт өргөргийн бүсээр хувьсан өөрчлөгдөж байдаг (Санжмятав.3, 2007).



**“ИЛЖИГТЭЙН ДООД ХЭСЭГ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАН,  
БАЯЖУУЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Цэнхэрмандал, Жаргалтхаан сумдын нутгийн ихэнх хэсгээр чулуусаг алаг өвс-хялгана зонхилж, хойд болон баруун хэсгээр баялаг алаг өвс-улалж-биелэг өвст, нугын алаг өвс-үетэнт тархсан. Харин Гичгэнэ багийн нутгаар харгана бүхий жижиг бутлаг үетэн-хиаг-хялганат, хиагт ургамал тархаж, өмнөд хэсгээр жижиг бутлаг үетэн-хялганат ургамал зонхилно.



Зураг №. 6 ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН УРГАМЛЫН ТАРХАЛТ

**Уур амьсгал:** Хуурайдуу сэрүүн зунтай, хахир өвөлтэй. Дэд бүтцийн сайдын тушаалаар “Өндөр уулын бүсэд” багтдаг. 1 дүгээр сарын дундаж температур - 23,6°С7 дугаар сарын дундаж температур +18,5°СЖилийн дундаж салхины хурд 5-10 м/сЖилийн хур тундасны нийлбэр 250-300 ммТехник технологийн шинэчлэл хийх шаардлагатай.

**Зам тээвэр:** Сумын газар нутаг дээгүүр Улаанбаатараас Өндөрхаан хүртэл хатуу хучилттай мянганы зам 80км урттай дайран өнгөрдөг. Аймгийн хэмжээнд төв замаас сумын төврүүгээ засмал замаар холбогдсон цорын ганц сум юм.Сумын 4 багийн 1-р баг нь шороон замаар холбогддог, 2-р багийн төв нь засмал замаас 2,5 км, 3-р баг нь 1км-т оршдог.

**Хот байгуулалт газрын харилцаа:** Сумын төвийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн өнөөгийн байдал Орон сууц олон нийтийн бүс -500 га Ногоон байгууламж -13,6 га Хөдөө аж ахуйн бүс 2510 га Өнөөгийн байдлаар 282 иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 40,5 га газар өмчилж, 205 га газар, 13 иргэн аж ахуйн нэгж Аялал жуулчлал, амралтын зориулалтаар 26,07 га газар, 45 иргэн аж ахуй нэгж үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зориулалтаар 2,14 га газар, 18 иргэн, 2 аж ахуй нэгж Төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарих зориулалтаар 108,1 га газрыг тус тус эзэмшиж байна.

**Мал аж ахуй:** Сумын хэмжээгээр нийт 141769 мянган мал тоологдсоноос цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 1,2 мянган толгой мал тоологдсон нь нийт малын 0,08 хувь байна. Үүнээс тэмээ-1, адуу-11262, үхэр-8865, хонь-70837, ямаа-50804 байна. 421 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 63%-ийг эзэлж байна



**Усан хангамж:** Сумын төв дээр цэвэр усны эх үүсвэрийн 2 гүний худагтай, мөн төв зам дагуу байрлалтай гуанз, цайны газрын орчимд 1 цэвэр усны эх үүсвэрийн гүний худагтай. Мөн сумын Баянмод багийн Төлүүгийн булан гэдэг газарт 150.0 сая төгрөгний өртөгтэйгээр улсын хөрөнгө оруулалтаар хөв байгуулсан. Цаашид Хужхан багт 1 хөв байгуулах шаардлагатай байна.

**Цахилгаан хангамж:** Сумын төв нь 1980-аад онд Багануур дүүргийн төвийн эрчим хүчний системд холбогдсон 24 цагийн гэрэл цахилгаантай. Дэд бүтэц үйлдвэрлэл хөгжих бүрэн боломжтой. 2008-2012 онд 40-өөд өрх шилжин ирсэн тул шинэ сууршлын бусэд ЦДАШ 5км-т шинээр татах шаардлага гарч байна.

**Дулаан хангамж:** Сумын хэмжээнд нийт 4 уурын зуух ажиллаж, төрийн төсвийн газруудыг дулаанаар хангадаг. Бусад нь объектууд ердийн галалгаагаар дулаанаа хангадаг. Цаашид төвлөрөөн хангамжинд холбогдох боломжтой.

**Ажилгүйдэл ядуурал:** Сумын хэмжээнд нийт 274 ажилгүй иргэн байна. Үүнээс бүртгэлтэй ажилгүй иргэн 32 байна. Нийт ажилгүй иргэдийн 44.9 %-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшигээр нь авч үзвэл 78.1% нь дээд, 3.1 % тусгай дунд, 6.25% нь бүрэн дунд, 12.5% нь бүрэн бус дунд боловсролтой хүмүүс эзэлж байна.

### БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

**Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл:** Хөрс хуулах, хүдэр олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ. Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо, уурхайд ажиллах машин техникүүдийн шингэн түлшний шаталтаас ялгарах утаа, хөө тортог, хорт хийнүүд, ажилчидын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол, өрөмдлөг, тэсэлгээний ажил хийх үед гарах тоос, шороо, хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эруул мэнд, хурээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө.

**Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл:** Төслийн зүгээс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол нөлөөлөл нь барилга угсралтын ажил болон төслийн үйл ажиллагаатай холбоотой уурхайн карьер, овоолго болон тээврийн хөдөлгөөн зэрэг эх үүсвэрүүдээс үүснэ.


**Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл :** Төслийн хүрээнд төлөвлөж буй ил уурхайн барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бүтцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол их үүснэ. Уурхайн үйл ажиллагааны явцад нүүрс-ус буюу шатахуун, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, мөн химийн бодисын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой. Шатахуун болон химийн бодисын агуулах, сав, машин техникийн тээвэрлэлт ачаалалтын үед асгаралт үүсэж хөрсний боломжит бохирдол ихэнхдээ үүсдэг.

**Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл:** Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох, Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох, Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах, Баяжуулах үйл ажиллагаа явуулахад химийн бодис алдагдахаас үүдэн хөрсний болон гүний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг борхирдуулах эрсдэлтэй байна.

**Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл:** Төслийн талбайд ил уурхай байгуулах, шимт хөрсний болон хаягдал чулуулгийн овоолго бий болгох, уурхайн зам, дэд бүтцүүдийн барилгын ажил хийгдэх зэрэгтэй холбоотойгоор хөрс хуулалт явагдах ба эдгээр үйл ажиллагаа нь ургамлан нөмрөгт шууд болон шууд бус нөлөөллийг үзүүлнэ. Мөн уурхайн байнгын үйл ажиллагаа ургамлан нөмрөгт дам нөлөөлөл богино ба урт хугацаанд үзүүлсээр байх юм.

**Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:** Барилга угсралтын үед ажиллах хүнд даацын автомашин, техник хэрэгслүүдийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих, Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох, Тоосжилтын улмаас ургамал ургах чадвараа алдан ургамлын арви багассанаас өвсөн тэжээлтнүүд хоол тэжээлийн хомсдолд орох, Төслийн ажилчид санаандгүй болон санаатайгаар амьтадыг устгаж болзошгүй, Шувууд утаанд хордох, цахилгаан хүчдэлд цохиулах зэрэг багтана.

**Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:** Төслийг хэрэгжүүлэхд ажиллах хүчийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах нь оршин суугчдын амжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээр байна.



ЗУРАГ №. 7 Төслөөс үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

- Дараах зурагт нөлөөлөл буурах функц ашиглан нөлөөллийн эрчим, орон зай, цаг хугацааны тархалтыг зураглалаа.
- Нөлөөлөл буурах зай болон нөлөөллийн эрчим нь төсөл хэрэгжих талбайгаас 300м радиуст нөлөөллийн эрчим хүчтэй, 500м радиуст нөлөөллийн эрчим дунд 800м-т радиуст аажмаар буурч байна.

#### 2.4 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл

Илжигтэйн доод хэсгийн алтны шороон орд ашиглах төсөл хэрэгжүүлэх нутгийн байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд төслийн үйл ажиллагааны зүгээс үзүүлэх нийт 113 нөлөөллийн тооцсон. Тэдгээр нөлөөлүүдийн 41 буюу 36% нь бага, 32 буюу 28% нь дунд, 26 буюу 23% нь их байгаа бол 14 буюу 12% нь маш их нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна.

Хүснэгт №. 6 Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөлөл байдлын үнэлгээний нэгдсэн дүгнэлт

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ				Нийт
		Бага	Дунд	Их	Маш их	
1	Агаарын чанар	3	3	5	2	13
2	Амьтны аймаг	17	7			24
3	Гадаргын болон газрын доорхи ус	8	2	7		17
4	Газрын гадарга болон хэвлий	3	2	3	11	19

**“ИЛЖИГТЭЙН ДООД ХЭСЭГ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАН,  
БАЯЖУУЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

5	Ургамлан нөмрөг	8	13	1		22
6	Хөрсөн бүрхэвч	2	5	10	1	18
	Нийт /тоогоор/	41	32	26	14	113
	Нийт /хувиар /	36%	28%	23%	12%	100%

Үүнээс үзэхэд төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь нөлөөллийн хувьд ДУНД зэрэг байна. Иймд төслийн барилга угсралт болон элс олборлох үйл ажиллагааны турш орчны хяналт шинжилгээг тогтмол хийж, аливаа үүсэх эрсдэл нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлэн, үндэсний болон олон улсын стандартын дагуу нөхөн сэргээлт, байгаль орчныг хамгаалах хөтөлбөрүүдийг уурхайн ТЭЗҮ болон энэхүү БОННУ-ний тайлангийн “Байгалийн аюул, уурхайн үйл ажиллагааны явцад гарч болзошгүй гэнэтийн ослын үнэлгээ”, “Уурхайн хаалт, нөхөн сэргээлт, экологи эдийн засгийн хохирлын үнэлгээ” болон “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” зэрэг бүлэгт заасан хувиар чиглэлийн дагуу уурхайн жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган зохих арга хэмжээг авч хэрэгжүүлж байх нь зүйтэй.



## БҮЛЭГ 4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 4.1 Менежментийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр тусгасан.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь “Монголламбер” ХХК-ийн “Илжигтэйн доод хэсэг”-ийн алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглан баяжуулах төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино. Энэ хүрээнд:

1. Тус төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг тусгасан сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө зэргийг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө;

2. Мөн тус төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус тус боловсруулсан болно.

Ингэхдээ, төсөл хэрэгжүүлэгч тухайн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлж болохуйц, бодиттой арга хэмжээг төлөвлөн тусгахыг эрхэм болголоо.

Тус төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, батлагдсан аргачлалыг баримтлан боловсруулсан бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд багтах дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно. Харин нөхөн сэргээлтийн төлөвлөгөө болон эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг тус тус оруулсан болно.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **3.740.0төг** зарцуулахаар төсөвлөв. Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дугаар сарын 01-ний дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг 12 сарын 30-ны дотор холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“ИЛЖИГТЭЙН ДООД ХЭСЭГ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАН,  
БАЯЖУУЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 7 БОМТ-ний зардалын задаргаа

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	1.2
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1.5
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1.5
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	550.0
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	550.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	680.0
9	Удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ	800.0
10	БОМТ-ыг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	220.0
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		7.000.000

**БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт №. 8 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
								2023 он	
1		<b>Агаарын чанар</b>							
	Уурхайн олборлолт болон тээврийн Хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: -Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил, -Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	Салхи ихтэй үед 7 хоногт 3 удаа, тогтуун үед 2 удаа усалж байх	Агаарын тухай хууль Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS(ISO)13688:2000 MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004 Бензинхөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
		Уурхайд орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай уялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	
		Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийх	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	

явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох -Тэсэлгээний ажлын үед үүсэх тоосжилт Ажиллагсад болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Хүнд машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол байлгах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш	-		-		+	
	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	-		-	-	+	
2	<b>Хөрсөн бүрхэвч</b>							
Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж	Өнгөн хөрсийг хуулан авах, хадгалах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	“Газрын тухай” хууль MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
	Уурхайн олборлолт явуулж буй хэсгээс баяжуулах үйлдвэр хүртэл тэмдэгжүүлэх	Үйл ажиллагааны турш	-		-		+	



<p>хөрс болон ургамлыг гэмтээх.</p> <p>Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах</p>								
<p>Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэх, сул шороо бүхий газруудаас тоос босох</p>	<p>Төслийн талбай дахь сул шороо бүхий газруудыг ургамалжуулах, мод бут тарих</p>	<p>Төслийн талбайд</p>	<p>-</p>		<p>-</p>	<p>Нөхөн сэргээх арга хэмжээнд тусгав</p>	<p>+</p>	<p>MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS</p>
<p>3</p>	<p><b>Усны нөөц, усны чанарт</b></p>							
	<p>Ажилчдын аюулгүй ажиллагааны дүрэмд усыг ариг гамтай хэрэглэх, хамгаалах тухай тусгаж өгөх</p>	<p>Ажилчдад</p>	<p>-</p>		<p>-</p>	<p>Осол эрсдэлийн менежментийн зардалд</p>	<p>+</p>	
	<p>Ажилчдын унд ахуйн усанд ашиглаж байгаа гүний худагаас дээж авч шинжилгээ хийлгэж,</p>	<p>Ажилчдын байрны хүрээнд</p>	<p>-</p>		<p>-</p>	<p>Орчны хяналт шинжилгээний зардалд</p>	<p>Сард 1 удаа</p>	

		усны найрлагыг тодорхойлуулж, ундны усны стандартад нийцэж буйг хянаж байх							
<b>4</b>	<b>Амьтны аймаг, ургамлан нөмрөг</b>								
	Үйл ажиллагаа явуулсантай амьтны нөөц хомсдох, ухсан нүх шуудуунд мал амьтан унахаас сэргийлэх	Уурхайн талбайд мал, амьтан унаж гэмтэхээс сэргийлэх зорилгоор хашаа хамгаалалт хийх	Уурхайн хүрээнд	-		-	240.0	+	
	Хог хаягдлыг ангилан ялгах хогын сав байршуулах	Хог хаягдалыг ил задгай хаяж хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтад үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	-		-	Хог хаягдлын менежментийн зардалд	+	Хог хаягдлын тухай хууль 2017 он
	Уурхайгаас алт агуулсан элс олборлох, хөрс хуулах зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Уурхайн тосгоны эргэн тойронд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Уурхайн тосгоны хүрээнд	-		-	100.0		
<b>5</b>	<b>Дуу чимээ</b>								

	Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах	Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх		-		-	-	+	
<b>Нийт</b>			<b>1200.0 сая.төг</b>						

**БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт №. 9 Техникийн нөхөн сэргээлт

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян,төг	Хэрэгжүүлэх хугцаа ба давтамж	Баримтлах эрх зүй баримт бичиг
	Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа болон ашиглалтын явцад уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглах зорилгоор нөхөн сэргээхэд техникийн нөхөн сэргээлтийн гол зорилт юм.	Техникийн нөхөн сэргээлт 5 га талбайд	Үйл ажиллагааны дуусмагц	–	–		Үйл ажиллагааны зардлаар	–	“Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008MNS5916:2008 MNS5917:2008
		Биологийн нөхөн сэргээлтийг 5 га талбайд							
Нийт 1.5 сая.төг									



**БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт №. 10 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг	Нийт зардал /сая.төг/	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
					2023		
1	<b>ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>						
	Зохион байгуулалтгүй аялал жуулчлал, зүй бус ашиглалтаас Байгалийн үзэсгэлэнт газруудын орчин хог хаягдлаар бохирдож, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр олон салаа зам гарч, байгалийн унаган төрх алдагдаж байна.	Тус сумын удирдлагуудтай зөвшилцөн уул уурхай, дэд бүтцийн нөлөөгөөр эвдрэлд орж орхигдсон 2.5 га -аас багагүй талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхийг Аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газраас санал өгсөн.	Үйл ажиллагааны эхэнд	Судалгаа хийх, Санхүүжүүлэх	-	ҮА-ний зардал (ДХ ажлын зардал)	MNS 5914:2015, MNS 4597:2013
2	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд	Сумын удирдлагуудтай зөвшилцөн 1 га талбайд мод тарихыг Аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газраас санал өгсөн.	Үйл ажиллагааны эхэнд				
		Уурхайн зам дагуу тунаах нуурын ойролцоо тарина					
<b>Нийт дүн, мян.төг</b>			<b>1.5 сая.төг</b>				

### БҮЛЭГ8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 онд тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө тусгагдаагүй болно.

### БҮЛЭГ9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна. Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

### БҮЛЭГ10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана.

Хүснэгт №. 11 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян\төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх, арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд уурхайн бүх ажилчдад	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2023 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Төслийн бүхий л үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2023 он	
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт		2	200		2023 он

Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	-	220	2023 он	
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	12			
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	-			
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	-			
Эрүүл мэнд	Ажилчдыг ажлын хувцас хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинен гутал, бээлий, хамгаалалтын нүдний шил маск) хангах	Бүх ажилчдад	220.0	2023 он	
	Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нарийвчлан мэргэжлийн байгууллагаар тогтоолгох	Төслийн нийт хугацаанд	220	2023 он	
<b>Нийт зардал (мян.төг)</b>			<b>550.0</b>		

**БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт №. 12 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
							2023 он	
Хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдол	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш				100.00	+	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011
Ахуйн хатуу хог хаягдлаар газрын гадарга бохирдох;	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.	Төслийн талбайн бүх барилга байгууламж уудад				100.00	+	Хог хаягдлын тухай хууль
Хог хаягдал, ШТМ-ын хаягдал хурын усаар дамжин гүний усыг бохирдуулах	Унд ахуйн усыг лабораторын шинжилгээнд тогтсон хуваарийн дагуу шинжлүүлж байх	Төслийн талбай дахь худгийн усанд				ОХШХ-т тусгасан аар	+	MNS 3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх MNS 0900:2005 Ундны ус. Эрүүл ахуйн

								шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Стандарт нийцсэн усаар хангах	Ундны усны стандарт хангасаар усаар ажилчдад үйлчлэх	Ундны усны хүрээнд				125.00	+	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлаг түүнд тавигдах шаардлага MNS 0900:2018
Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх харьяа нийтийн үйлчилгээний албатай хог хаягдлын гэрээ хийх	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, ажилчидын бие засах газар болон бохир ус хуримтлуулах цэгийг холбогдох хууль, стандартын шаардлагад нийцүүлэн хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байхаар төлөвлөн шинээр байгуулах, үүссэн шингэн хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах	Ахуйн хаягдлын хүрээнд				50.0	+	Усны тухай хууль, 2012 он Гүний усыг бохирдолоос хамгаалах ерөнхий шаардлагууд. MNS 3342:1982
	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр. Гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх						155.0	
Нийт		550.0 мян.төг						

**БҮЛЭГ12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

Хүснэгт №. 13 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж 2023 он	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
<b>Хөрсний бохирдол</b>								
1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 2 цэг сонгох /Уурхайн кемп орчим, уурхайн ухаш/	Хагас жил тутамд	Жилд 2 удаа	15.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1жил /15.0/ НИЙТ 120,0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж - 15.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	/Засварын цех, ШТС/	Хагас жил тутамд	Жилд 2 удаа	20.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1 жил х 20,0 Нийт 160,0 хүнд металлын шинжилгээ	MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ



								1 дээж- 20.0 төг/	
<b>Усны хяналт шинжилгээ</b>									
2	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	2023 он	Жилд 2 удаа	40.0	40.0*2 удаа х 1жил НИЙТ 80.0		MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3	Усны түвшин усны ундарга нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх	Гүний худгийн ус, Гол	2023 он					
<b>ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2023 ОНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>							<b>680.0</b>		

**БҮЛЭГ13. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

Хүснэгт №. 14 БОМТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Зардал мян.төг	Хугацаа 2023 он
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		2023 он
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	Уурхайн хэмжээнд	Удирдлагын түвшинд		2023 он
4	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлыг жил бүрийн тайланг БОАЖЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүрийн 12 сард
5	Байгаль хамгаалахад сум багийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	Уурхайн хэмжээнд	Удирдлагын түвшинд		2023 он
6	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	Уурхайн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр		2023 он
7	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг бэлтгэж, шаардлагатай газруудад байрлуулах	Уурхайн хэмжээнд	-	250.00	2023 он
8	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах сургалт зохион байгуулах, галын аюулгүй ажиллагааны талаар дүүргийн ГТХХэлтэстэй хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзүүлэх сургууль хийх	Уурхайн хэмжээнд	Ослын сургалттай хамтран хэрэгжүүлэх		3-р улирал

9	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Улирал бүр
10	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүр
11	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	Уурхайн хэмжээнд	50.0	100.0	Жилд 2 удаа
12	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг дүүргийн Онцгой байдлын хэлтсээр гаргуулах	Дотоод төлөвлөлтөөр			Жилд 1 удаа
13	Нийгмийн хариуцлагын хүрээнд багын иргэдэд цагаан сар болон бусад үйл ажиллагааг дэмжих үүднээс тусламж өгөх	Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн гэрээгээр			2023 он
<b>Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал</b>				800.0 мян.төг	

**БҮЛЭГ14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

Хүснэгт №. 15 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Хэнтий аймгийн сумдын ажлын хэсэгт танилцуулах	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумын засаг захиргаанд хүргүүлнэ	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	2023.11.01-нд хүргүүлэх	-	“Патрикейн” ХХК” ХХК-ын байгаль орчны мэргэжилтэн	
<b>Нийт</b>		<b>220.0 мян.төг</b>				